

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

ОРШИЛ	3
БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	4
I.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
I.2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ	5
I.3. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ.....	5
БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
II.1. ФИЗИК ГАЗАРЗҮЙ	7
II.2. УУР АМЬСГАЛ, АГААРЫН ЧАНАР	7
II.3. УСАН ОРЧИН	7
II.4. ХӨРСӨН БҮРХЭВЧ.....	7
II.5. УРГАМЛАН НӨМРӨГ	8
II.6. АМЬТНЫ АЙМАГ.....	8
II.7. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ	8
БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
III.1. АГААРЫН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	9
III.2. ГАЗРЫН ГАДАРГА БОЛОН ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	9
III.3. УСНЫ НӨӨЦӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	9
III.4. УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	10
III.5. АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	10
III.6. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛСТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	10
III.7. Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө	11
III.8. Төслөөс нийгэм, эдийн засгийн байдалд үзүүлэх нөлөө	11
БҮЛЭГ IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	12
БҮЛЭГ V. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
V.1. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
5.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
10.1.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	17
10.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	17
10.1.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
10.1.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
10.1.6. Тэрбум мод тарих төлөвлөгөө	18
10.1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	19
10.1.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20
10.1.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	20
10.1.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	21
10.1.11. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	23
X.II. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ.....	24
БҮЛЭГ XI. ГОЛ ҮР ДҮНГҮҮД БА НЭГДСЭН ДҮГНЭЛТ	25
XII. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	26



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1. Төслийн ерөнхий мэдээлэл	4
Хүснэгт № 2. Тусгай зөвшөөрөлтэй талбайн газарзүйн солбицол.....	5
Хүснэгт № 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
Хүснэгт № 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
Хүснэгт № 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
Хүснэгт № 6. Тэрбум мод тарих төлөвлөгөө	18
Хүснэгт № 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	19
Хүснэгт № 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт № 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	21
Хүснэгт № 10. Мониторингийн цэгүүд	22
Хүснэгт № 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	22
Хүснэгт № 12. БОМТ-ий хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	23
Хүснэгт № 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	24



ОРШИЛ

“Найртын Дэнж” ХХК-ийн Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын нутагт орших MV-022571 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Замын шанд” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах, тэрбум мод үндэсний хөтөлбөр, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Энэхүү төслийн БОННУ нь 2026 оны 07-р сарын 09-ний өдөр батлагдсан бөгөөд БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хүртэл хугацаанд БОННУ-д тусгасан ажлуудыг бүрэн хэрэгжүүлж амжихгүй байх магадлалтай болохыг анхаарна уу.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 33,261,911 төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.




ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

I.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт № 1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр	“Замын шанд” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
Ашигт малтмалын төрөл	Алт (шороо)
Төслийн байршил	Хэнтий аймгийн Жаргалтхаан сум
Төслийн хугацаа	Ордыг 3 жил ашиглах ба хаалт, нөхөн сэргээлтийн хугацааг нэмж тооцсон дүнгээр 5 жил байна.
Төсөл хэрэгжүүлэгч	“Найртын Дэнж” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011616097
Регистрийн дугаар	6085571
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар, Чингэлтэй, 4-р хороо, барилгачдын талбай, хийморь а, 28 тоот
Тусгай зөвшөөрөл	543.27 га талбай бүхий ашигт малтмалын MV-022571 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдөр “Найртын дэнж” ХХК-д олгосон байна.



Зураг № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн агаар сансрын байрзүйн зураг

Улаанбаатар хотоос зүүн тийш 235 км, Чингис хотоос баруун тийш 120 км, Чандганы нүүрсний уурхайгаас баруун тийш 70 км, Цэнхэрмандал сумаас зүүн тийш 30км, Өмнөдэлгэр сумаас 35км зайд оршино.

- Талбайн нэр: Од
- Ордын нэр: Замын шанд
- Талбайн нийт хэмжээ: 543.27 га.



ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт № 2. Тусгай зөвшөөрөлтэй талбайн газарзүйн солбицол

Цэгийн дугаар	Газарзүйн солбицол					
	Уртраг			Өргөрөг		
	Град	мин	сек	Град	мин	сек
1	109	19	46	47	36	0
2	109	19	46	47	38	54.5
3	109	18	57.7	47	38	54.5
4	109	18	57.7	47	36	0

I. 2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Ашигт малтмал, Газрын тосны хэрэг эрхлэх газрын 2021.10.28 -ны өдрийн шийдвэрээр Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын нутагт орших 543.27 га талбайд “Од” нэртэй ашигт малтмал ашиглах MV-022571 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгосон.

I. 3. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

Уурхайн хил хязгаар, үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Үйлдвэрийн агуулгатай хэсгийн дундаж өргөн нь 150-200м-ийн хооронд хэлбэлзэнэ. Ордын нийт урт 2.0км. Орд нь 1400-1550 метрийн өндөрт байрлана. Хэмхдэс чулуулгийн ихэнхийг 95% нь хайрга, дайрга эзлэх ба 20х30 см-ийн жижиг бул чулуу үлдсэн 5%-ийг эзэлнэ. Тус ордын хөрсний дундаж зузаан нь 2.14 м элсний дундаж зузаан нь 1.24 м, алт агуулсан элсний нэг давхаргаас бүрдэнэ.

Элсийг олборлох үед элсний таазнаас 20 см, улнаас 20 см бохирдуулж ашиглана. Ордын бохирдолын тооцоог нөөцийн блок тус бүрээр бодож гаргасан.

2026 онд явагдах уулын ажил, ажиллах горим

Ил уурхайн ажилчид 14/14 хоногийн ВАХТ-ын системээр ажиллах ба хоногт 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайн хөрс хуулалтын ажлыг 6-р сараас 10-р сарыг дуустал, элс угаалтын ажлыг 6-р сарын дунд үеэс 10-р сарыг дуустал үргэлжлэхээр тооцоолж ТЭЗҮ -ийг боловсруулав. Уурхайн хөрс хуулалтыг дотоод овоолго үүсгэн хуулах бөгөөд 2026 онд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэх бөгөөд 3 дахь жилд биологийн нөхөн сэргээлтийг ордын хэмжээнд хийхээр төлөвлөв. Уулын ажил нь цаг агаарын саатал, төлөвлөгдөөгүй техникийн засвар үйлчилгээ, сул зогсолтоос хамааран эхний жилд баяр ёслол, амралтын өдрүүд 7 хоног, цаг агаараас хамаарсан сул зогсолт 14, уурхайн жилд ажиллах бодит хоног 150 хоног тус тус ажиллахаар байна.

2026 онд В-7, В-8, В-9, В-10 блокуудыг бүрэн олборлож нийт 196.1 мян.м3 хөрс хуулж, 158.1 мян.м3 элс олборлон баяжуулахаар төлөвлөж байна.

Үржил шимт хөрс хуулалт

Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2 м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн ирмэг дагуулан түрж овоолно. Энэ нь дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг хэмнэх давуу талтай юм.

Хөрс хуулалтын ажил

Талбайн үржил шимт хөрсийг хуулсаны дараа хөрсний чулуулгийг экскаватор-автосамосвалын хослолоор хуулан сонгон авсан талбайд гадаад овоолгоор уулын ажлыг



ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

үргэлжлүүлэн, хоосон орон зай гарахад дотоод овоолгоор уулын ажлыг явуулахаар төлөвлөв.

Элс олборлолтын ажил

Олборлолтын ажлыг экскаватор-автосамосвалын хослолоор ухаж ачин тээвэрлэж, угаан баяжуулах хэсгийн дэргэд байрлах элсний түр овоолго руу зөөж угаан баяжуулахаар төлөвлөв. Мөн угаасан хоосон чулуулгийг эргүүлэн тээвэрлэж уурхайд нөхөн дүүргэлт хийхээр төлөвлөж байна.

Ашиглалтын систем

Ордын уул техникийн нөхцөл, элсний биетийн хэлбэр ба байршил, хөрсний зузаан зэрэг нь ордыг ил уурхайн аргаар, автотээвэртэй гадаад болон дотоод овоолготой, ашиглалтын системээр ашиглана.

Засвар, техникийн үйлчилгээ ба агуулахын аж ахуй

Тус уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь тоног төхөөрөмж авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд шаардлагатай зарим нэг техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах, тавьж олгох зэрэг ажлыг гүйцэтгэдэг. Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг засварын дагнасан газраар буюу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлдэг. Засварын газар нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Шатах тослох материалын агуулах. ШТМ хадгалахад зориулж 25тн-ын ган сав 1 ш, тос тосолгооны материалуудыг зориулалтын савтай нь хадгалан хэрэглэнэ. ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан, зориулалтын тоноглолоор хангасан байна.

Сэлбэг материалын агуулах.

Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материал хадгалахад сэлбэг материалын агуулах нь уурхайн хотхонд буюу засвар механикийн хэсгийн хажууд байна.

Машины зогсоол.

Уурхайн элс, хөрсний тээвэрт 250 тн даацтай 2 ширхэг автосамосвал ажиллана. Харин уурхайн ажилчдын машин 1 ширхэг, ачааны машин 1 ширхэг, үйлчилгээний машин 1 ширхэг, уурхайн тоосжилт дарах усалгааны машин 1 ширхэг, түлшний машин 1 ширхэг нийт 7 машин байна. Машинуудыг засварын газрын дэргэдэх машины ил зогсоолд байрлуулна.



БАЙГАЛЬ ОРЧНЫ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Замын шанд нэртэй алтны шороон ордын талбай нь Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын нутагт оршдог. Улаанбаатар хотоос зүүн тийш 235 км, Өндөрхаанхотоос баруун тийш 120 км, Чандганы нүүрсний уурхайгаас баруун тийш 70 км, Цэнхэрмандал сумаас зүүн тийш 30км, Өмнөдэлгэр сумаас 35км зайд оршино.

II.1. Физик газарзүй

Далайн төвшнөөс дээш дунджаар 1358 м өргөгдсөн. Жаргалтхаан-уул нь далайн төвшнөөс дээш 1614 м өндөртэй, нутгийн тахилгат, унтарсан галт уул юм. Физик газар зүйн хувьд Хэнтийн нуруу, түүний захын салбар уулс тал хээр хосолсон газар нутагтай.

II.2. Уур амьсгал, агаарын чанар

Газрын гадарга нь Хэнтийн нурууны өвөр бэл, уулс толгодлог хэсэгт багтах бөгөөд үнэмлэхүй өндөр нь 1400-1550м далайн төвшнөөс дээш өргөгдсөн, газрын хэрчигдэл нь талархаг, харьцангуй өндөр нь 100-150 метрт орших нам уулс, өргөн хөндийнүүдтэй газар юм. Ордын хөндийн гадаргуугийн налуу нь 5 градус болно. Жилийн агаарын температурын хамгийн дулаан нь зундаа 8 сард +28°C, хамгийн хүйтэн нь өвөлдөө 1 сард -40°C хүрдэг. Цасан бүрхүүлийн зузаан нь дунджаар 10 см, зарим зудтай үед үүнээс ч илүү байдаг. Салхины хурд Монгол орны нэгэн адил баруун хойт зүгээс 4-8 м/с байх ба хаврын улиралд заримдаа 9-18 м/с хүрч салхи шороогоор шуурна. Өвс ургамлын хувьд тал хээрийн агь, шивээт хялгана, хазаар өвс, дагуурын агь зэрэг ургах ба уулын орой ар талд нь ховроор шилмүүст ойн төгөл байна.

II.3. Усан орчин

Хэрлэн голын ай савд багтдаг бөгөөд усан сүлжээ сайн хөгжсөн нутаг юм. Энэ нутгийн усны голын сүлжээ нь Хэнтийн нуруунаас эх авсан Цэнхэрийн гол юм. Түүнд зүүн гар талаас Баянмод, Хужхаан, Өргөн, Хадагтай зэрэг жижигхэн горхинууд цутгана. Хэрлэн ба түүний томоохон цутгалуудын нэг болох Цэнхэр гол байнгын устай, голын голдирол нь 40-80 м өргөн, гүн нь 1-3 м, зарим газраа илүү гүнзгий байдаг. Урсгалын хурд нь 0,5-1 м/сек хүрдэг. Гол хөндийн усны урсацын орчимд бургас, баглуур мэтийн ургамал тохиолдохоос гадна ялангуяа Цэнхэрийн голын орчимд говирхог шавар бударгана бас байна. Бусад жижиг гол, горхиуд нь хур тундас багатай үед тасардаг ба зарим нь шургах буюу бүр хатаж ширгэдэг. Бороо хур ихтэй үед ихэнх булгуудын ундарга нэмэгдэж гол горхиуд сэргэж, заримдаа үерийн байдалтай болох ба мөн олон салаалсан шинэ голдирол, гуу жалга үүсгэх явдал ажиглагдана.

II.4. Хөрсөн бүрхэвч

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын нутагт байрлах төслийн талбайд уулын хар хүрэн хөрс тархсан байна.

Төсөл хэрэгжих судалгааны талбайд хад асга бүхий нам уулсаар уулын хар хүрэн хөрс зонхилон илрэх бол тэдгээр уулсын ар болон өвөр хажуу, бэлийн системд сайр чулуурхаг, нимгэн ялзмагт давхарга бүхий уулын хүрэн хөрс, уулын нимгэн хар шороон хөрсний хэв шинжийг тус тус ялган тодорхойллоо.



БАЙГАЛЬ ОРЧНЫ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

II.5. Ургамлан нөмрөг

Төслийн талбайн район нь Монгол орны байгалийн мужлалаар хээрийн бүсэд багтана. Төслийн талбай, түүний орчмын газар нутаг нь Монгол орны ургамал газарзүй нь мужлалаар Евразийн хээрийн их муж Төд азийн дэд муж Алтанширээгийн тойрогт хамаарна (Монгол Улсын үндэсний атлас, 2009).

Нутгийн хойд, зүүн хойд хэсэгт Хэнтийн нурууны захын ой бүхий уулс байх ба тэнд нарс, шинэс, хуш, хус, улиас, улиангар, бургас зэрэг мод ургана. Мөн хад, нэрс, мойл, өрөл, улаалзгана, бөөрөлзгөнө, самар ихээр ургана. Уулархаг нутгаар уулын нугын хар, хар хүрэн, намгийн цэвдэгт цайвар хүрэн хөрстэй ба ойт хээр, өндөр уулын бүсийн навчит болон өвслөг ургамал зохилон ургана. Хээр талдаа хиаг, хялгана, ерхөг, согоовор, агь, ганга голлосон нарийн өвс ургамалтай. Мөн бамбай, шар болон цэнхэр дэгд, лидэр, таван салаа, нохойн хошуу, ганга, чихэр өвс, хамба шарилж, цөс өвс зэрэг эмийн ховор ургамал ургадаг.

II.6. Амьтны аймаг

Төсөл хэрэгжиж буй нутаг нь газарзүйн мужлалаар Монголын хээрийн ба ойт хээрийн дэд мужийн Монгол Дагуурын тойрогт хамаарна. Сумын нутагт хандгай, халиун буга, зэрлэг гахай, шилүүс, бор гөрөөс, чоно, үнэг, дорго, хярс, хур, сойр, ногтруу, идлэг шонхор зэрэг ан амьтан, жигүүртэн шувууд элбэг.

II.7. Нийгэм эдийн засаг

Жаргалтхаан сум нь засаг захиргааны 5 багтай бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар эрэгтэй 1165, эмэгтэй 1028, нийт 2193 хүн ам, 708 өрхтэй. Нийт 708 өрхөөс малчин өрх 335, мал бүхий 188 өрх байна. Жаргалтхаан нутгийн хүн амын дийлэнх хэсэг нь Халх тооны Буриад ястан бөгөөд цөөхөн мал аж ахуй, мод түлээ бэлтгэх, аян жин тээх, ан ав хийх зэрэг аж ахуйг эрхэлдэг байна. Сумын брэнд бүтээгдэхүүн нь Солонгос технологиор үйлдвэрлэсэн “Жаргалтхаан кимчи” Хус модны үндсээр хийсэн эмээлийн мод, буриад талх барьдаг.

Судалгааны талбай нь Улаанбаатар-Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн улсын баталгаат авто зам дайран өнгөрөх бөгөөд Цэнхэрмандал, Жаргалтхаан сумд нь дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, өндөр хүчдэлийн шугамтай, төв замд ойр бөгөөд Хужхааны цагаан тугалганы олборлох үйлдвэр ажилладгаас гадна Улаанбаатар-Өндөрхааны холбооны шугам зэргэлдээ өнгөрөх ба ой модны нөөцтэй зэрэг олон талын тааламжтай зүйлүүдийг дурдаж болно.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сум нутаг дэвсгэрийн хэмжээ 275 мянган га талбайтай, баруунаас зүүн тийш 71 км өргөн уудам газар нутгийг эзлэн оршино. Сумын төв Улаанбаатар хотоос 230 км, Чингис хотоос 100 км-т оршдог. Сумын нутаг дэвсгэр баруун урд болон баруун талаараа Дэлгэрхаан сумтай, баруун хойд, хойд хэсгээрээ Цэнхэрмандал сумтай, зүүн хойд талаараа Өмнөдэлгэр сумтай, зүүн, зүүн урд хэсгээрээ Хэрлэн, Мөрөн сумдтай, өмнөд хэсгээрээ Баянмөнх сумтай тус тус хиллэнэ.



ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

III.1. Агаарын орчинд үзүүлэх нөлөө

Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хорт хий агаар орчныг бохирдуулах, олборлолтын явцад суларсан нарийн ширхэгт тоос агаарт салхиар болон техникийн хөдөлгөөнөөр дэгдэх зэрэг сөрөг нөлөөлөл байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Төслийн талбайн дотоод тээвэрлэлтийг аль болох олон салаа зам гаргахгүйгээр тээвэрлэх,
2. Орчны агаарт ялгаруулах хорт утаа хийг багасгахын тулд техникийн засвар, үйлчилгээг тогтмол хийж байх.

III.2. Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөө

Ил уурхайн аргаар үйл ажиллагаа явуулах учраас газрын гадаргад өөрчлөлт орно. Хөрс хуулалт, гадаад болон дотоод овоолго, баяжуулах үйлдвэр, ажилтнуудын түр амьдрах байр зэрэг бүхий л уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид нөлөөлнө.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Барилга байгууламж, овоолгын суурь зэргийн шимт хөрсийг тусад нь хуулан авч хураана.
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх,
3. Тээвэрлэлтийг явуулахдаа замын тогтсон маршрут гаргах, мөрдүүлэх, мөн хүнд даацын тээврийн хэрэгслийн зөөвөрт явах үеийн хурдыг тогтоох (хурдтай явах тусам тоосжилт нэмэгдэн техникт эвдрэл гарна), хяналт тавих,
4. Тогтсон маршрутын дагуу замын тоосжилт дарах усалгаа хийх,
5. Хатуу хаягдлыг ялган ангилж хадгалах, төвлөрсөн цэгүүдэд зайлуулах хэрэгтэй.

III.3. Усны нөөцөд үзүүлэх нөлөө

Технологийн онцлог нь газрын доорх усыг ашиглах учраас газрын доорх усны түвшин буурах, бохирдох нөлөөлөл байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Тус ордод ашиглах усыг өөрсдийн гаргасан гүний худаг болон шүүрлийн усаар хангах юм. Гүний худаг болон шүүрлийн татах ус дамжуулах шугам хоолойн эх дээр баталгаажуулсан тоолуур суурилуулан усны хэрэглээнд хяналт тавин ажиллах шаардлагатай.
2. Ундны зориулалтаар хэрэглэх усыг багасгах, усны чанарт тогтмол хяналт шинжилгээ хийж байх.
3. Эргэлтийн усан сангуудаас алт угаан баяжуулсан бохир ус хөрсөнд нэвчихээс сэргийлж эргэлтийн усан сангийн ёроолыг ус үл нэвчүүлэх тусгай зориулалтын полиэтиленээр хучих шаардлагатай. Эргэлтийн усан сангаас ус алдаж болзошгүй тохиолдолд урьдчилсан арга хэмжээ авах, усан сангийн даланд хананы бэхлэгээ хийх, усан санг үерээс байнга хамгаалж байх.



ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

III.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө

Хөрс хуулалт, овоолго хийх, дотоод тээвэрлэлтийн явцад ургамлан бүрхэвч устаж дарагдахаар байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Олборлолт явуулсан талбайд устсан ургамлыг нөхөн сэргээж тарих,
2. Хавар намрын хуурайшилттай үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх.

III.5. Амьтны аймагт үзүүлэх нөлөө

Эерэг нөлөөллүүд

1. Амьтны аймгийн мониторинг нь энэ бүс нутаг орчмын амьтны аймгийн тухай шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангах чухал ач холбогдолтой.

Сөрөг нөлөөллүүд

2. Хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн дуу чимээ, замын тоос зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах зэрэг сөрөг нөлөөлөлтэй,
3. Олборлолт явуулж байгаа газарт мал, амьтан унах,
4. Хөрс хуулалтын үед үүссэн нүх, хөрсөнд орогнох, үүрлэх мэрэгч, мөлхөгч, шувуудын үүр ноохой сүйтгэгдэх зэрэг болно.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

Ажилчид болон нутгийн иргэдэд байгаль орчныг хамгаалах, тэр тусмаа амьтны аймгийн талаарх сургалт сурталчилгаа хийх, зэргэлдээх уурхайнууд, нутгийн иргэдтэй хамтарсан мониторинг сүлжээ бий болгох (гар утасны БАЙГАЛЬ АПП ашиглах.)

Бүс нутгийн биологийн төрөл зүйл, тоо толгойг хамгаалах үүднээс орон нутгийн захиргаа, иргэдийн төлөөлөл, байгаль орчны албаны ажилтантай байнга хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд тэдгээрт туслалцаа үзүүлэх, санал солилцох, тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

III.6. Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх нөлөө

Төслийн талбайд 2021 онд гүйцэтгэсэн Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайланд тусгаснаар талбайд энгийн аргаар хайгуул явуулахад талбайн урд захад 7, төв хэсэгт 15, нийт 22 тооны эртний булш илрүүлж, бүртгэн тэмдэглэсэн байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

1. Хүн амьтнаас түүх соёлын дурсгалт газрыг хамгаалах, оруулахгүй байх,
2. Түүх соёлын дурсгалт газрыг эвдэхгүй байх,
3. Хэрэв ашигт малтмал ашиглалтын явцад хүн малын яс, шавар ваар савны хагархай, янз бүрийн хүрэл, төмөр эдлэл, түүний хэлтэрхий, хугархай гэх мэт хүний гараар хийсэн ямар нэг эд өлгийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд орон нутгийн удирдлага, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж хамгаалалтанд авах ба дурдсан мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж малтлага судалгаа хийлгэхийг зөвлөж байна.



ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

III.7. Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

Хөдөлмөрийн, ХАБЭА тухай хууль, бусад холбогдолтой дүрэм журам, стандартын шаардлагуудыг мөрдөх, дотоодын хяналтын журам аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг нийт ажилтнуудад мөрдүүлэх, хяналт тавих шаардлагатай.

III.8. Төслөөс нийгэм, эдийн засгийн байдалд үзүүлэх нөлөө

- Төслийн нөлөөллийн бүсэд төвлөрсөн суурьшил байхгүй,
- Төслийн үйл ажиллагааны үед орон нутагт ажлын байр бий болно,
- Орон нутгаас нийлүүлэх боломжтой хүнсний хангамж, ахуйн хангамж, түлш шатахуун нийлүүлэлт зэрэг материаллаг эрэлт үүснэ,
- Улс орны төсөвт мөнгөн хуримтлал бий болгоно,

Мөн үйл ажиллагааны явцад техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс эсвэл гэнэтийн аюул осол гарснаас улбаалан ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг нийгэм эдийн засгийн олон сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай



БҮЛЭГ IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт: Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагаа эхлээгүй үед хийгдэж байгаа учраас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл: Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга: Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан



ГОЛ ЗОРИЛТ БА ХАМРАХ ХҮРЭЭ

байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-г боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

Байгаль хамгаалах төлөвлөгөө:

- ✓ Төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ
- ✓ Уул уурхайн төслийн хаалтын үед авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, хамрах хүрээ;
- ✓ БОМТ-г хэрэгжүүлэх хүний нөөц, БО-ны удирдлагын бүтэц зохион байгуулалт;
- ✓ БОМТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө;

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр:

- ✓ Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;
- ✓ Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- ✓ Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- ✓ Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

БОМТ-ний бүтэц: БОМТ-ний бүрэлдэхүүнд 5 бүлэг, 7 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн товч танилцуулга
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч танилцуулга
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө
7. Дүгнэлт



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ V. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

V.I. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнөөр үүсэх тоосжилт болон тээврийн хэрэгсэлийн яндангаас ялгарах хорт хий байна гэж үзсэн. Мөн техник, тээврийн хэрэгсэлийн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ байна. Тоосжилтыг бууруулахын тулд замын тоосыг усаар дарах болон барьцалдуулагч бодис ашиглан тоосыг тодорхой хугацаанд барих зэргийг зөвлөмж болгосон. Тээврийн хэрэгсэлийн яндангаас ялгарах хорт хийг бага байлгахын тулд техник, тээврийн хэрэгслүүдийн оношилгоо, тохиргоо, засвар үйлчилгээг тогтмол хийх шаардлагатай. Дуу чимээний бохирдлоос ажилчдыг хамгаалах дуу чимээ багасгах чихэвчээр хангахыг зөвлөж өгсөн

Хүснэгт № 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	2026 он	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх, салхи ихтэй үед тоос дарах усалгаа хийх	Дотоод тээврийн зам	100.0	Жил бүр	-Агаарын тухай хууль, -Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
2.	-Дуу шуугиан ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх	Дуу шуугианы хэмжилт хийж, дуу, шуугиан бүхий машин механизмын үр ашиггүй ашиглалтыг багасгах. (Уг багажийг хэрэв БОШТЛ, “ОС МТ” ХХК зэргээс түрээслэвэл түрээсийн зардал нэг удаа 30,000 төг байна.)	Уурхайн орчим	30.0	Дууны түвшин хэмжигч NL- 04 багажаар хэмжилтийг хийнэ	-MNS 12.1.06:1988 Хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартын систем. Дуу чимээний хамгийн өндөр түвшин. Аюулгүй байдлын шаардлага.

Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд усыг ариг гамтай ашиглах, хурын усыг хуримтлуулж замын тоос дарахад ашиглахыг зөвлөмжилсөн. Мөн үер борооны усаар зөөгдөн элдэв хог хаягдлаар бохирдол үүсэхээс сэргийлж далан шуудуу барих шаардлагатай. Ус ашиглалтын бүртгэл хөтөлж, усны тайланг тогтмол гаргаж зохих газар нь хүргүүлж тайлагнах, ус ашиглалтай холбоотой гэрээ, зөвшөөрлийг авч, хүчинтэй хугацааг хянаж ажиллахаар төлөвлөсөн. Ахуйн шингэн хог хаягдлаар хөрс бохирдож газрын гүний ус бохирдохоос сэргийлж бага оврын цэвэрлэх байгууламжыг төлөвлөж өгсөн.



[illegible]

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд Шимт хөрсний хадгалалтыг стандартын дагуу хийж усалж арчилж байх, замын тэмдэг тэмдэглэгээг байршуулж түүний дагуу техник тээврийн хэрэгслийг зорчуулж байхыг зөвлөмжилж төлөвлөгөөнд тусгаж өгсөн.

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөлтийн дагуу хийж гүйцэтгэх, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх зэргийг зөвлөмжилж өгсөн. Мөн тоосжилтыг бага байлгах зорилгоор ногоон байгууламжийг ажилчдын хотхон орчимд бий болгож, арчилж байхаар төлөвлөлөө.

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	2026 он	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Хүнд даацын машин	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг байрлуулах	Уурхайн замд	300.0	Тухай бүрт	-MNS 3297:1991 Хөрс. Хот суурин газрын эрүүл ахуйн үзүүлэлтүүд
2.	механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх, Шатах тослох материал асгарсанаар хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	ШТМ-ын агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгож газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлэх	ШТМ-ын агуулах, засварын талбай	750.0	2026 он	-MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ -Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль,
3.	Ургамлан нөмрөг устах, зүйлийн тоо буурах, бэлчээрийн хумигдах	Нутгийн ургамлын үрийг түүж бэлтгэх талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн зөвлөгөө авч орон нутгийн иргэд, уурхайн ажилчидыг дайчлан саман ерхөг, крыловын хялгана зэрэг нутгийн үетэн ургамлын үрийг шимт хөрсний овоолгод ургуулж турших, үрийн нөөц бэлтгэх	Уурхайн орчмын ургамлан нөмрөг, шимт хөрсний овоолго	3,900.0	2026-2028	Ургамал хамгааллын тухай хууль Байгалийн ургамлын тухай хууль MNS 5918:2023 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага”

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд ажилчид хууль бус ан агнуур хийхгүй байхад хяналт тавих, талбайн орчимд үзэгдсэн зэрлэг амьтдын бүртгэл хөтлөх, халдварт өвчин тарааж болзошгүй амьтад хог хаягдлын цэгт цугларахгүй байх арга хэмжээ авч тогмтол ачуулж зайлуулж ариутгал хийлгэж байх, мал амьтад гүн ухаш нүхрүү унаж эрсдэхээс сэргийлж хамгаалалтын хашаа барих зэрэг ажлуудыг төлөвлөж өгсөн.



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	2026 он	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Уурхайн ойр орчмын газарт нутагладаг ан амьтдын амьдрах орчинд шууд бус байдлаар нөлөөлөх	Биологийн олон янз байдлыг хамгаалах, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр уурхайн ажилчид болон нутгийн иргэдтэй хамтран “Байгаль” аппликейшн ашиглаж амьтны мониторингийн судалгаа хийх, түүний хэрэгжилтийг хангуулахад анхаарч идэвхтэй ашиглагчдад урамшуулал олгох	Нутгийн иргэд, уурхайн ажилчид	500.0	2026-2030 он	"Амьтны аймгийн тухай" хууль: 6.1.7 дахь заалт: үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх
2.		Малын гоц халдварт өвчин гарахаас сэргийлж зэрлэг амьтан агнахгүй байх, мэргэчид ихсэхээс сэргийлж хогийн цэгт ариутгал халдваргүйжлийн арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх	Уурхайн орчим	150.0	Жил бүр	
	Нийт			27,530.0		

10.1.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Төслийн батлагдсан ТЭЗҮ-д тусгасны дагуу уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг ашиглалтын 3 жил дууссаны дараа 4-5 дахь жилд хэрэгжүүлнэ. Иймд 2026 онд нөхөн сэргээлтийн ажил хийхгүй гэж үзэн энэхүү тайланд нөхөн сэргээлтийн зардал тусгаагүй болно

10.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд Газрын мэдээллийн нэгдсэн санд П.Гансаруул, П.Түвшинбаатар гэх 2 өрхийн өвөлжөө, хаваржааны зориулалт бүхий газар орсон байна. Эдгээр айлууд нь төслийн нөлөөллийг бүсэд ороогүй хэдий ч Төсөл хэрэгжүүлэгчийн санаачилсанаар эдгээр 2 айлуудад нөхөн олговор олгох, нийгмийн хариуцлагын хүрээнд ажлын байраар хангахаар төлөвлөж байна.

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	2026 он мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	8	9
1.	П.Гансаруулын өвөлжөөний газар	Нөхөн олговор олгох	Эзэмшил газрын хэмжээнд	5,000.0	Жилд 1 удаа	
2.	П.Түвшинбаатарын өвөлжөөний газар	Нөхөн олговор олгох	Эзэмшил газрын хэмжээнд	5,000.0	Жилд 1 удаа	
Нийт				10,000.0		



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

10.1.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт № 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	2026 он /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Түүх соёлын дурсгалт газрыг хамгаалах	Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа хиргисүүрүүдэд тэмдэг тэмдэглэгээ тавих, тээврийн хэрэгсэл зорчуулахгүй байхаар хамгаалах арга хэмжээ авах	Тусгай зөвшөөрлийн талбайд бүртгэгдсэн 22 ш хиргисүүр	300.0	Жилд 4-5 булш	МУ-ын соёлын өвийг хамгаалах тухай хууль
Нийт				300.0		

10.1.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт № 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хамгааллын арга хэмжээ	2026 он /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Дэлгэрхаан уулын БНГ-т Хэнтий аймгийн Байгаль орчны газартай хамтран аргаль хонь, халиун бугад чиглэсэн биотехникийн арга хэмжээ авна	13,331.9	2026 он	Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль Хэнтий аймгийн байгаль орчны газрын 2025 оны 07-р сарын 23-ны өдрийн 414 тоот дугаартай “Санал хүргүүлэх тухай” Хэнтийн аймгийн орон нутгийн захиргаатай байгуулсан 2026 оны 05-р сарын 18-ны өдрийн 01 тоот дугаартай “Хамтран ажиллах гэрээ”
Нийт дүн		13,331.9		

10.1.6. Тэрбум мод тарих төлөвлөгөө

“Найртын дэнж” ХХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигийн 2-т заасан тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд жил бүр 600 ш модыг тарихаар Хэнтийн аймгийн орон нутгийн захиргаатай байгуулсан 2026 оны 05-р сарын 18-ны өдрийн 01 тоот дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-нд тусгасан байна. Үүнийг Хэнтий аймгийн Байгаль орчны газраас санал болгосон газарт тарихаар төлөвлөжээ.

БОАЖ-ын сайд, Сангийн сайд нарын 2021 оны 07-р сарын 09-ний өдрийн А/172,116 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын норматив”-ыг ашиглан тооцсон болно.

Хүснэгт № 6. Тэрбум мод тарих төлөвлөгөө

№	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	2026
---	--------------	-------------	------



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1	Модны тоо	ш	600
2	Шилмүүст модтны суулгацаар ойжуулах, нөхөн сэргээх норматив	мян.төг	2,700.0
3	Тарьцаар ойжуулах, нөхөн сэргээсэн талбайн арчилгааны норматив	мян.төг	850.0
4	Мод тарих талбайн хэмжээ	га	1.2
	Нийт	мян.төг	4,260.0

10.1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс шалтгаалж гэнэтийн осол гарахаас сэргийлж тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, үзлэг хийж засварлах, хянах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх шаардлагатай. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллаагүйн улмаас хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй гэнэтийн осол эрсдэлээс сэргийлж уурхайн ажил эхлэхийн өмнө тогтмол ажилчдын дунд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сургалт зохион байгуулдаг байх, болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н болон АУТөлөвлөгөөтэй байх шаардлагатай.

Хүснэгт № 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	2026 он	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гэнэтийн гал түймрийн аюулын үед үүсэх эрсдэл	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид	Үйл ажиллагааны туршид	200.0	2026-2028 он	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхой-лолт, ерөнхий анги
2		Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Уурхай орчимд	Иж бүрэн	500.0	2026 он	
3	Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах	Уурхай орчимд		150.0	2026-2028 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003-(сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012.05.17)
Нийт					850.0		



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

10.1.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Найртын дэнж” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай. Ахуйн шингэн хог хаягдлаар хөрс бохирдож газрын гүний ус бохирдохоос сэргийлж АЦБ-ын шингэн бохирыг тогмтол соруулж зайлуулж байх шаардлагатай.

Хүснэгт № 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	2026 он	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан, ялгах, хог хаягдлыг дахин ашиглах	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	Энгийн хог хаягдлаас үүсэх нөлөөллийн бүс	100.0	2026-2028 он	Хог хаягдлын тухай хууль; “Ариун цэврийн тухай” хууль; БОАЖ-ын сайдын 2018 оны А/18 тушаал Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах; БОАЖ-ын сайдын 2018 оны А/443 тушаал Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага; БОАЖ-ын сайдын 2018 оны А/445 тушаал Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар;
2		Хатуу хог хаягдлыг зориулалтын битүүмжилсэн саванд хадгалж, орон нутагтай гэрээ байгуулан тогтоосон цэгт зайлуулж байх	Төслийн талбайд	200.0	2026-2028 он	
3	Аюултай хог хаягдал болон шатах тослох материалаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй	Үйл ажиллагаанаас гарсан хэрэглэсэн батарей, ажилласан тос, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан аюултай хаягдал авах цэгт гэрээ байгуулан зайлуулах	Аюултай хог хаягдал	300.0	2026-2028 он	
4	Шингэн хаягдал	Бохирын цооногийг 70-90% дүүргэлттэй болох үед соруулан зайлуулж хэвших	Бохирын цооног	100.0	2026-2028 он	
		Нийт		700.0		

10.1.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журамыг байгаль орчны мэргэжилтэн тогтоож мөрдөх, Байгаль хамгаалахад ОН-н иргэдийн оролцоог идэвхижүүлэх уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах, БО-г хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах, уурхайн ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг шаардлагатай.

Хүснэгт № 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	2026 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн удирдлагын авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд	Ажилчдыг ХАБЭА хувцас хэрэгсэлээр хангах	Уурхайн ажилчид	2,000.0	Жил бүр	-MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
4		Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	Уурхайн удирдлага	3,000.0	5 жилд 1 удаа	-Шуугианы норм, аюулгүй ажиллагаа-ны ерөнхий шаардлага -MNS 12.4. 005 - 1985 Хөдөлмөр хамгаалал. Шуугианаа хамгаалах хэрэгсэл ба аргууд
Нийт				5,000.0		

10.1.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Найртын дэнж” ХХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа болон үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөлөх байдлын үнэлгээний нэг чухал баримт бичиг юм. ОХШХ нь БОХТ-тэйгөө нягт уялдсан байх бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 сард холбогдох сум, аймаг, төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

л үйл ажиллагааг “Найртын дэнж” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.



Хүснэгт № 10. Мониторингийн цэгүүд

ОХШХ-ийн мониторингийн цэг		
Агаарын шинжилгээний цэг	109° 19' 19.19"	47° 37' 49.45"
	109° 19' 12"	47° 37' 31.08"
	109° 19' 33.59"	47° 36' 33.48"
Ургамлын мониторингийн цэг	109° 19' 22.79"	47° 38' 35.52"
	109° 19' 26.39"	47° 39' 23.41"
	109° 19' 4.8"	47° 37' 39.72"
Усны шинжилгээний цэг	109° 19' 1.2"	47° 37' 51.6"
	109° 19' 37.21"	47° 36' 41.4"
Хөрсний шинжилгээний цэг	109° 19' 19.19"	47° 37' 49.08"
	109° 19' 12"	47° 37' 33.6"
	109° 19' 33.59"	47° 36' 36.36"

Зураг № 3. Мониторингийн цэгийн зураглал

Хүснэгт № 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	2026 он	Баримтлах стандарт ба аргачлал
Агаарын чанар					
1	PM ₁₀ , PM _{2.5} , NO ₂ /азотын давхар исэл SO ₂ /хүхэрлэг хий CO/нүүрстөрөгчийн дутуу исэл	Нөлөөлөлд өртөөгүй хяналтын 1 цэгт, Ил уурхай, зам, баяжуулах хэсэг – 3 цэг	Улиралд 1 удаа	420.0	-MNS 17.2.316-88 Хот суурин газрын агаарын чанарыг хангах -MNS 3384:1982 Агаар мандлын сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага
2	Дэгдэмхий органик нэгдэл	Угаан баяжуулах хэсэг, уурхайн хотхон орчимд – 2 цэг	Өөрийн багажаар тогтмол	200.0	-MNS 5885:2008 агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ техникийн шаардлага -MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага
Хөрсний чанар					
1	Агрохимийн үзүүлэлт	Нөлөөлөлд өртөөгүй хяналтын 1 цэгт, Ил уурхай орчимд, ажилчдын хотхон, зам, баяжуулах хэсэг - 4 цэгт	Улиралд 1 удаа	450.0	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд.



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2	Хүнд элементийн бохирдол	Ил уурхай, Засварын газар, зам	Жилд 2 удаа	210.0	MNS 3297:2019 Хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлт MNS 5850:2019 -Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ
3	Эрүүл ахуй	Ажилчидын суурин орчимд-1 цэг	Жилд 2 удаа	70.0	
Усны чанар					
1	Ундны усны ерөнхий химийн найрлага	Унд ахуйн усанд хэрэглэх гүний худаг-1 цэг	Жилд 2 удаа	90.0	-MNS /ISO/ 5667-11:2001 Усны чанар. Дээж авах. 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж, -MNS 0900:2018, Хүний унд ахуйн зориулалттай усны чанарын норм, -MNS6148-2010, Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Хаягдал усны шинжилгээ	Эргэлтийн усан сангаас-1 цэг	Жилд 2 удаа	110.0	
Ургамлын мониторинг					
1	Төслийн талбайд ойр орших ургамлын бүлгэмдлийн хяналтын 5 цэгийг сонгож ургамлын төрөл зүйл, ургамлан нөмрөгийн дээд доод бүрхэц, ургамлын зүйлийн тоо, арви бүрхэц, бүлгэмдэлд эзлэх хувь зэргийг гаргах, мониторингийн судалгаа хийх		Төслийн талбайн болон ойр орчим	4,000.0	Ургамлын тухай хууль Мэргэжлийн байгууллагатай хамтрах
Нийт				5,550.0	

10.1.11. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт № 12. БОМТ-ий хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	Хэнтий аймаг, Жаргалтхаан сумын, Багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах	Хэнтий аймгийн Жаргалтхаан сум
2	БОНХАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тайлангийн эх хувь, албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	Тайлагнах	БОАЖЯ-нд
3	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхижүүлэх уулзалт зөвлөгөөг зохион байгуулах тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Хагас жил тутам буюу 6, 11 сард	Цаашид анхаарах асуудал	ЗДТГ, БОГ, ИНХ-ын байр



Х.П. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт № 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2026 он
		мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7,530.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Нөхөн олговор олгох төлөвлөгөө	10,000.0
4	Нийгмийн нөлөөлөл, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	300.0
5	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13,331.9
6	Тэрбум мод төслийн хүрээнд	4,260.0
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	850.0
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	700.0
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	5,550.0
10	Тухайн жилийн удирдлага зохион байгуулалт	5,000.0
11	Байгаль орчны АУДИТ хийлгэх зардал	
Нийт		33,261.9



БҮЛЭГ XI. ГОЛ ҮР ДҮНГҮҮД БА НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Хэнтий аймгийн Жартгалтхаан сумын нутаг дэвсгэрт орших “Найртын Дэнж” ХХК-ийн MV-022571 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Замын шанд алтны шороон ордыг ашиглах төсөлд 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 33,261,911 төгрөг гарахаар тооцоолсноос 50% –ийг нь Байгаль орчин, нөхөн сэргээх санд байршуулах зайлшгүй шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон цаг хугацаанд нь хэрэгжүүлэх шаардлагатай.

“Замын шанд алтны шороон ордыг ашиглах төсөл”-ийн алтны шороон ордын үйл ажиллагааны явцад хөрс хамгийн ихээр элэгдэл эвдрэлд орох учир нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг цаг тухайд бүрт мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн нөхцөлд энэхүү төслийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтойгоос гадна шинээр ажлын байр нэмэгдэх, орон нутагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх төлөвлөгөөтэй байна



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ХII. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Сайдын тоот тушаал, 2019 он
6. Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын нутагт орших Замын шанд алтны шороон ордыг ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2026 он
7. Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын нутагт орших Замын шанд алтны шороон ордыг ашиглах ТЭЗҮ 2024 он
8. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014 он

